# СОЁЛЫН ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙГ ХУУЛЬ БУСААР ХИЛ НЭВТРҮҮЛЭХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

*Б.Одбаатар*

*ДХИС-ийн Удирдлагын академийн*
*Цагдаагийн удирдлага, стратегийн*
*профессорын багийн профессор,*
*доктор (Ph.D), цагдаагийн хурандаа*

***Товч агуулга:*** *Энэхүү нийтлэлээр соёлын дурсгалт зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх арга замын талаар авч үзэхийг зорилоо.*

***Түлхүүр үгс:*** *Соёлын дурсгалт зүйл, соёлын үнэт зүйл контрабанда /хууль бусаар хил нэвтрүүлэх/, гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлого.*

Аливаа улс орны соёлын өв, дурсгалт зүйл тухайн улс, үндэстний олон зуун жилийн оюун ухаан, хүч хөдөлмөрийн агуу бүтээл, эртний соёл иргэншлийн хөгжлийн түүхийн бодит гэрч байгаад зогсохгүй дэлхийн хүн төрөлхтөний түүхийн хөгжлийн нэгэн хэсэг юм.

Түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлж чадах түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны ач холбогдол бүхий эд зүйлсийг нийтэд нь соёлын өв хэмээн тодорхойлдог бөгөөд түүнийг хууль бусаар хил нэвтрүүлэх нь аливаа ард түмний бүр цаашлаад хүн төрөлхтөний соёл иргэншил, хөгжлийн түүхийн эсрэг гэмт хэрэг юм. Ард түмний өв соёл, үнэт нандин бүхнийг бараа таваар мэт болгож, улс үндэстний харилцан ойлголцол, нийгмийн нягтаршил, эв нэгдэл хамтын санамж, дурсамжийг бүдгэрүүлж, сэв суулгаж, зарим тохиолдолд эргэж сэргээшгүйгээр хорлож, хохироож байгаа энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх нь хүн төрөлхтөний үүрэг хариуцлага бөгөөд энэхүү үүргээ хүн бүр биелүүлэх ёстой.

Монгол Улсын Соёлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2., Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хуулийн 3 дугаар зүйлийн 3.4. дэх хэсэгт "Түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлж чадах түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны ач холбогдол бүхий эд зүйлсийг нийтэд нь соёлын өв" гэж тодорхойлон заасан. Соёлын өвийг уламжлагдан ирж буй шинж байдлаар нь:

а) биет соёлын өв;

б) биет бус соёлын өв[54] гэж хоёр ангилдаг ба биет өвийг мөн дотор нь хөдлөх[55], үл хөдлөх[56] гэж 2 хувааж үздэг байна.

Харин түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдол бүхий зүйлийг түүнийг эзэмшиж байгаа

[54] Биет бус өвд Монголын ард тумний оюун санаагаар бүтсэн эх хэл, ардын зан заншил, мэдлэг ухаан, дуу хөгжим, наадам, ардын арга ухаан, уламжлалт технологи зэрэг соёлын өвийн олон төрөл багтдаг.

[55] Хөдлөх өв, үнэт зүйлс гэдэгт музейн үзмэр, сүм хийд, хувь хүнд хадгалагдаж байгаа эд өлгийн зүйлсийг хамааруулдаг.

[56] Үл хөдлөх өв, үнэт зүйлс гэдэгт хээр хөдөө орших буй эртний булш хиргисүүр, хадны сүг зураг, бичээс хөшөө чулуу, эртний хот, сүм хийдийн туурь зэрэг археологи, палеонтологи, уран барилгын дурсгал хамрагддаг.

өмчийн аливаа хэлбэрийг[57] харгалзахгүйгээр түүх, соёлын дурсгалт зүйл хэмээн үздэг. Үүнд:

1. Археологийн дурсгал. *(эртний хүний оромж, отог бууц, оршин сууж байсан ул мөрийг хадгалсан соёлт давхрага, ашигт малтмал олборлож, боловсруулж, үйлдвэрлэл эрхэлж байсан газар, булш хиргисүүр, хөрсөн доорхи шороон булш, нууцлагдсан бунхан, хадны агуй, хөмөг дэх оршуулга, тахилгын газар, бүх төрөл, хэлбэрийн хөшөө чулуу, хадны сүг зураг, бичээс);*

2. Уран барилгын дурсгал. *(эртний хот суурины үлдэгдэл, балгас, хэрэм, цайз болон уран барилгын цогцолбор, сүм дуган, хийд, гудамж, талбай, байшин барилга);*

3. Эд өлгийн зүйлс. *(угсаатны хувцас, чимэглэл, гэр болон аж ахуйн тоног хэрэгсэл, хөдөлмөриийн багаж зэвсэг, хөгжмийн зэмсэг, уламжлалт ардын тоглоом наадам, шашны эд зүйл);*

*4.* Сурвалж бичиг, гар бичмэл, барын болон хэвлэмэл ном судар, зэрэг бичгийн дурсгал, гэрэл зураг, кино, дүрс бичлэг;

5. Дүрслэх бүх төрлийн бүтээл. *(уран зураг, уран баримал, хөөмөл, цутгамал, сийлбэр, зээгт наамал, хатгамал, цаасан шуумал, шавар болон вааран эдлэл);*

6. Түүхэн хүмүүсийн амьдрал, үйл ажиллагаатай холбоотой байшин барилга, эд өлгийн зүйл, баримт бичиг;

7. Түүх, соёлын дурсгалт газар;

8. Эртний хүний болон сөнөсөн амьтан, ургамал, бичил биетний бүх төрлийн олдвор;

9. Эрдэс, үнэт чулууны ховор олдвор;

10. Эд өлгийн бусад үнэт зүйл зэрэг нь түүх, соёлын дурсгалт болон үнэт зүйлсэд багтдаг байна[58].

Мөн түүнчлэн түүх, соёлын үнэт зүйлийг түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдлыг нь үндэслэн мөн дараах байдлаар нь:

1. түүх, соёлын хосгүй үнэт зүйл;

2. түүх, соёлын үнэт зүйл;

3. ердийн үнэт зүйл гэсэн 3 зэрэглэлд ангилан авч үздэг бөгөөд эдгээрийн зэрэглэл, үнэлгээг холбогдох эрдэм шинжилгээний байгууллагын саналыг үндэслэн, соёл шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх мэргэжлийн зөвлөлтодорхойлдог[59].

Монгол Улс 1992 онд анхны ардчилсан Үндсэн хуулиа баталж, түүндээ “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна[60]” гэж заасан нь соёлын дурсгалт зүйлсийг хадгалан

[57] Төрийн болон хувийн өмчийн аль аль нь үүнд нэгэн адил хамаарна.
[58] Монгол Улсын төв болон орон нутгийг судлах музейд нийт 205000 гаруй түүх, соёлын дурсгалт зүйлс хадгалагдаж байгаагийн 289 нь хосгүй үнэт дурсгал юм.
[59] Соёлын өвийг хамгаалах тухай Монгол Улсын хуулийн 5 дугаар зүйл. Түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэл, үнэлгээ. Эх сурвалж. http://www.legalinfo.mn/law/details/455
[60] Монгол Улсын Үндсэн хууль. http://www.legalinfo.mn/law/details/367?lawid=367

хамгаалах нь зөвхөн төрийн бодлогын хэмжээний асуудал байгаад зогсохгүй Монгол Улсын үндэсний хэмжээний асуудал болохыг гэрчилж байна.

Иймд соёлын дурсгалтзүйлсийн эрх зүйн хамгаалалтын тулгуур нь Монгол Улсын Үндсэн хууль бөгөөд түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль эрх зүйн баримт бичиг тухайлбал, Соёлын тухай хууль[61] , Эрүүгийн хууль[62], Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль[63], Соёлын өвийг хамгаалах тухай хууль[64], Гаалийн тухай хууль[65], Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал[66], Төрөөс соёлын талаар баримтлах бодлого[67], түүнчлэн Монгол Улсын нэгдэн орсон соёлын өв. соёлын дурсгалт зүйлийг хамгаалахтай холбоотой олон улсын конвенц[68]нь түүний хадгалалт, хамгаалалтын эрх зүйн орчинг бүрдүүлж байна.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлд зааснаар төрийн өмчлөлд байгаа соёлын дурсгалт зүйлийг гагцхүү судалж шинжлэх, олон нийтэд сурталчлах, сэргээн засварлах зорилгоор түүний хадгалалт, хамгаалалтын найдвартай нөхцлийг бүрдүүлсний үндсэн дээр улсын хилээр нэвтрүүлж болох бөгөөд энэ тохиолдолд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тогтоосон хугацаа, зөвшөөрөлтэйгээр хил нэвтрүүлдэг[69]. Түүнчлэн хувийн өмчид байгаа соёлын дурсгалт зүйлийг эргүүлж авчрах нөхцөлтэйгээр харилцан тохиролцсон гэрээний үндсэн дээр судалж шинжлэх, сурталчлах, сэргээн засварлах зориулалтаар ашиглахаар соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлтэйгээр улсын хилээр нэвтрүүлж болохыг хуулиар зохицуулж өгсөн хэдий боловч сүүлийн 5 жилд тусгай зөвшөөрөл авч улсын хилээр нэвтрүүлсэн түүх, соёлын дурсгалт зүйлийн судалгаанаас харахад түүхийн үнэт, ховор зүйлийг эзэмшигч хувь этгээд тэр бүр ийм төрлийн үйл ажиллагаанд оролцох хүсэл сонирхлоор төдийлөн бага байна[70].

Харин хууль бусаар Монгол Улсын хилээр нэвтрүүлэн гадаад улсад гаргасан түүх, соёлын дурсгалт зүйл, мөн зохих зөвшөөрлийн дагуу улсын хилээр гаргасан түүх, соёлын дурсгалт зүйл алдагдсан, үрэгдсэн тохиолдлыг судалж тогтоосны үндсэн дээр тэдгээрийг Монгол Улсын өмч болгон зарлах бөгөөд.энэ тохиолдолд түүнийг эргүүлж татаж авчрах ажлыг соёл, шинжлэх ухааны асуудал

[61] Соёлын тухай хууль. Цахим эх сурвалж, холбоос: http://www.legalinfo.mn/law/details/454

[62]Эрүүгийн хууль. Цахим эх сурвалж, холбоос: http://www.legalinfo.mn/law/details/50

[63] Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль. Цахим эх сурвалж, холбоос: http://www.legalinfo.mn/law/details/479

[64]Соёлын өвийг хамгаалах тухай хууль. Эх сурвалж.http://www.legalinfo.mn/law/details/455

[65]Гаалийн тухай хууль. Цахим эх сурвалж: http://www.legalinfo.mn/law/details/209?lawid=209

[66]Монгол Улсын Их хурлын 2010 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолоор батлагдсан. Цахим эх сурвалж, хоn6оос:http://www.nsc.gov.mn/?q=node/119

[67]Монгол Улсын Их хурлын 2012 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан. Цахим эх сурвалж, холбоос: http://www.opera-ballet.mn

[68]Соёлын үнэт зүйлсийн хууль бус экспорт, импорт, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай конвенц. НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО) 1970 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Парис хотноо баталж, 1972 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр хүчин төгөлдөр болсон. Эх сурвалж, хоn6оо:http://www.legalinfo.mn/law/details/1207?lawid=1207

[69]Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Соёлын өвийн хэлтсийн 2013.12.25-ны өдөр гаргасан судалгаагаар гадаад улс руу үзэсгэлэн, судалгаа, шинжилгээгээр 2012 онд 9, 2013 онд 11 түүх, соёлын үнэт зүйлд тусгай зөвшөөрөл олгон гаргасан байна.

[70]Түүх, соёлын үнэт дурсгалт зүйлийг эргүүлж авчрах нөхцөлтэйгээр, соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр 2 жилээс дээшгүй хугацаатай гадаадад гаргадаг.

эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон цагдаагийн байгуулага хууль тогтоомжид заасан журмын дагуу зохион явуулахаар зохицуулсан байдаг.

Хэдийгээр энэ харилцаа эрх зүйн зохицуулалтын орчин зохих түвшинд бүрдсэн байгаа ч соёлын дурсгалт зүйлийг хууль бусаар олж авах, хууль бусаар хил нэвтрүүлэх нь гэмт этгээдүүдийн байнгын гэж хэлж болохуйц үйл ажиллагаа болж, улмаар түүнийг ашиг орлогын эс үүсвэрээ болгох сонирхол давамгайлж сүүлийн жилүүдэд олон улсын шинж чанартай болтлоо өргөжиж байгаа нь түүнтэй тэмцэх, илрүүлэх, таслан зогсоох нь зөвхөн Монгол Улсын хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаа бус олон улсын хэмжээний өргөн цар хүрээг хамарсан асуудал болж хувираад байна. Үүний нэг тод жишээ нь Монголын говиос олдоод гэмт бүлэглэлийн замаар орж хаа холын Америк орныг зорин одсон үлэг гүрвэлийн гарал үүслийн тухай нэхэмжлэлийг Монгол Улс гаргаж тавьснаар нутагтаа ирсэн “Тиранозавр батаар” хэмээх үлэг гүрвэлийн шуугиан тарьсан хэрэг юм. Үүний мөрөөр хуулийн байгууллага шалгаад дахин 22 үлэг гүрвэлийг мөн хууль бусаар хил нэвтрүүлж гаргасан гэмт хэргийн бүлэглэлтэй холбоотой хэрэгтухайн үедээ шалгагдаад өнгөрсөн. Энэ том олдвороос эхлээд бусад олон хосгүй үнэт зүйл гэмт этгээдүүдийн гараар орж хууль бусаар хил нэвтрэн гарч гадны орныг зорин одсон тоо баримт олон байна. Тухайлбал, Монгол Улсын иргэн Б 2019 оны 11 сарын 25-нд төмөр зэвсгийн түрүү үед хамаарах түүхийн хосгүй үнэт, дурсгалт зүйл байж болзошгүй хүрэл тогоонуудыг хууль бусаар худалдан борлуулахыг завдсан үйлдлийг Тагнуулын ерөнхий газраас шуурхай илрүүлэн, үйлдэл дээр нь таслан зогсоож соёлын биет өвийг хууль бусаар хилээр гарах, бусдад худалдагдахаас урьдчилан сэргийлж, хэргийг харьяаллын дагуу цагдаагийн байгууллагад шилжүүлжээ[71].

Эндээс дүгнэхэд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааны уялдаа холбоо хангалтгүйг харуулж байгаа төдийгүй, нөгөө талаас түүнтэй тэмцэх цогц арга хэмжээг боловсруулж, яаралтай арга хэмжээ авах цаг болсныг гэрчилж буй бодит баримт юм.

Түүгээр ч барахгүй нийгмийн амьдралын хурдацтай өөрчлөлт, даяарчлал, нээлттэй зах зээлийн үед Монгол Улсын соёлын өвийн хууль бус худалдаа, хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх тэмцлээ олон улсын жишигт хүргэх, түүнийг илрүүлэх, нотлох ажиллагааны шинэ арга тактикийг боловсруулан гаргах нь цаг үеийн шаардлагаар бодитойгоор тавигдаж байна.

Хүрээгээ улам тэлж буй соёлын дурсгалт зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх тухай асуудал зөвхөн Монгол Улсын төдийгүй дэлхийн нийтийн сэтгэл зовоосон асуудал болоод байна.Иймд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх түүнийг илрүүлэх, нотлох ажиллагааг онолын үндэстэй боловсруулан гаргаж, түүнд тулгуурлан эрх зүйн орчинг боловсронгуй болгох, үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Нөгөө талаас эртний эдлэл зарж борлуулдаг дэлгүүрүүдийн гол үйлчлүүлэгч нь гадны, тэр дундаа БНХАУ-ын иргэд байна. Тэгэхээр хууль бусаар хил давсан соёлын дурсгалт зүйл хэн нэгний хувийн цуглуулагад орохоос илүүтэй, урд хөршийн эсвэл бусад аль нэг орны музейн үзмэр болж байна. Тэдгээр нь боломжийн өндөр үнээр зарагдаж, гэнэтийн том ашиг, орлогыг авчирдаг учраас аймаг, нийслэлд буй төрөлжсөн хэдэн музей, сүм, хийдээ хулгайлан дээрэмддэг, түүнийг нь дамжуулж хилээр хууль бусаар гаргадаг гэмт

[71] Цахим эх сурвалж. https://www.arslan.mn/social/news/611235.shtml

хэргийн бүлэглэл, сүлжээ үүсэн хөгжөөд зохион байгуулалттай болсныг хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаагаар шалгаж тогтоогоод байна.

Энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, нотлох ажиллагааны сул талын гол шалтгааны нэг ньхууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа сул, энэ чиглэлийн үйл ажиллагаагд хяналт тавих эрх бүхийбайгууллагын хяналт сул зэрэг олон шалтгаантай холбон тайлбарлаж болно.

Соёлын дурсгалт зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэргийг илрүүлэх чухал үүргийг гүйцэтгэх субъектын нэг нь төрийн тусгай чиг үүрэгтэй байгууллага талаасаахил хамгаалах болон гаалийн байгууллага юм. Чухамдаа гаалийн үзлэг, шалгалтаас нууж хууль бусаар хил нэвтрүүлж байгаа гэмт хэргийн үйлдэл нь хилийн хамгаалалтын дэглэм, журам зөрчиж хилээр нэвтрүүлж байгаа үйлдлээс хавыүй илүү төдийгүй энэ төрлийн хэрэг, зөрчлийн ихэнх нь дээрхи үйлдлийн аргаар үйлдэгдэж байна.

Иймд соёлын дурсгалт зүйлийг хууль бусаар улсын хил нэвтрүүлэх хил, гаалийн үзлэг, шалгалтаас нууж хил нэвтрүүлэхийг завдсан гэмт хэрэгтэй тэмцэхэддараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзлээ.

**1. Соёлын дурсгалт зүйлсийн бүртгэл-мэдээллийн нэгдсэн цахим санг байгуулан бүтээлчээр ашиглах.“Соёлын** дурсгалт зүйлсийн нэгдсэн бүртгэл-мэдээллийн цахим сан”-гсум, аймаг, нийслэл, улсын хэмжээнд шаталсан хэлбэрээр байгуулан, улсын хэмжээнд нэгдмэл удирдлагаар ханган Монгол Улсад соёлын өвийн бүртгэл-мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, улмаар энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх хууль сахиулах байгууллагууд шуурхай мэдээлэл олж авах боломжоор хангах хууль эрх зүйн орчинбүрдүүлэх шаардлагатай байна.

Өнөөдөр ийм төрлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан Монгол Улсын хэмжээнд байхгүйн улмаас хил, гаалийн үзлэг шалгалтаар нэвтрүүлж байгаа эд зүйлийг түүх, соёлын ховор олдвор, дурсгалт зүйл мөн эсэхийг газар дээр нь шалгаж тогтоох боломжгүй төдийгүй, түүнийг жинхэнэ мөн эсэхийг ялган таньж мэдэхэд хүндрэлтэй байдлыг үүсгэж байна. Харин нэгдсэн бүртгэл мэдээллийн сан бий болсноор хилийн шалган нэвтрүүлэх боомтод үзлэг шалгалт явуулж байгаа алба хаагчид харьцуулан шалгах боломж бүрдэж, түүний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлээд зогсохгүй, энэ төрлийн гэмт хэргийг шуурхай илрүүлэх, шалгахаднэн чухал ач холбогдолтой

**2. Хууль бус малтлагыг таслан зогсоох ажлыг хууль сахиулах байгууллага болон энэ чиглэлийн ажлыг хариуцсан төрийн байгууллагын хамтын ажиллагааг** эрчимжүүлэх.Палеонтологийн олдворт газруудад хэн дуртай нь дураараа эрэл хийж, байгалийн өгөршилтөөр илэрсэн олдворыг хулгайн замаар авч зарах, хууль бусаар хил нэвтрүүлэн худалдах үзэгдэл ихэд даамжирч энэ мэт ажиллагаанд тухайн олдворт газартай ойр нутагладаг малчид, аймаг, сумын наймаачид, жуулчны баазын хүмүүс идэвхитэй оролцдог, тэднийг хөрөнгө санхүүгийн хувьд байнга дэмжиж, цуглуулсан олдворыг нь хил давуулан худалддаг зохион байгуулагдсан сүлжээ бий болсон байгаад хууль сахиулах байгууллага анхаарлаа хандуулж, түүнтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх, хамтын ажиллагааны уялдаа холбоог сайжруулах шаардлага бий болсон байгаад дүгнэлт хийх цаг болсон байна.

Учир нь Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн “8.11. Сум, дүүргийн Засаг дарга тухайн нутаг дэвсгэрт зөвшөөрөлгүй малтлага, хайгуул хийж байгаа мэдээллийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 7

хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалт нь энэ төрлийн мэдээллийг хэн, хаана, ямар шугамаар хүлээн авах, мэдээллийн мөрөөр арга хэмжээ зохион байгуулах санхүүжилтийн эх үүсвэр хаанаас гарах зэрэг харилцааг зохицуулсан эрх зүйн актыг өнөө хүртэл боловсруулж гаргаагүй, хууль бус малтлагыг таслан зогсоох ажлыг улсын хэмжээнд шуурхай удирдан зохион байгуулах механизм байхгүй эзэнгүйдэж байгаатай шууд холбоотой юм.

Монгол Улс өргөн уудам нутаг дэвсгэртэй, түүх, соёлын арвин дурсгалтай тул хууль бус малтлага, антиквариатын худалдаатай холбоотой соёлын өвийн зөрчлийн талаарх мэдээллийг цаг тухайд нь хугацаа алдалгүй иргэдээс хүлээн авч, цагдаа, тагнуул, олон нийтийн байгууллагуудтай хамтран ажиллах шаардлагатай байна. Иймээс Соёлын өвийг хамгаалах тухай хуульд “Соёлын өвийн хууль тогтоомжийн зөрчлийн талаарх мэдээллийг урамшуулах журмыг Монгол Улсын Засгийн газар батална” гэсэн заалт тусгах хэрэгтэй байгаа юм.

Цаашид Эрүүгийн хуулинд ч эртний амьтан ургамлын, нэн ялангуяа хууль бус малтлагад хамгийн ихээр өртөж байгаа үлэг гүрвэлийн чулуужсан өндөг, яс, археологийн олдворыг сүйтгэсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгах, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, багажийг хурааж авах зэрэг зүйл заалтыг тусгах шаардлагатай гэж дүгнэж байна.

**3. Соёлын дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэхэд тавих хяналтыг** чангатгах.Соёлын дурсгалт зүйлийг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.1, 20.2 дахь заалтын дагуу төрийн болон хувийн өмчлөлд байгаа түүх, соёлын хосгүй үнэт болон үнэт дурсгалт зүйлийг судалж шинжлэх, сурталчлах, сэргээн засварлах зорилгоор түүний хадгалалт, хамгаалалтын найдвартай нөхцөлийг бүрдүүлсний үндсэн дээр соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр 2 жилээс дээшгүй хугацаагаар улсын хилээр нэвтрүүлж байна. Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 219 дүгээр тогтоолоор баталсан “Улсын хилээр төрийн хяналтан дор нэвтрүүлэх бараанд экспорт, импортын лиценз олгох журам”, “Улсын хилээр лицензтэй нэвтрүүлэх кодлосон барааны жагсаалт”-ын дагуу БСШУЯ-наас олгосон зөвшөөрөл /лиценз/, гэрээ, бусад дагалдах бичиг баримтыг үндэслэн гаалийн бүрдүүлэлт хийж, гаалийн хилээр түр хугацаагаар /2 жил/ гаргадаг.

Соёлын дурсгалт зүйлсийг хилээр гаргах зөвшөөрөл олгохдоо сурталчилгаа, судалгаа шинжилгээ, сэргээн засварлах зориулалтаар эргэж ирэх нөхцөлтэй ба археологи палеонтологийн олдвор, эд өлгийн зүйлсийн он цагийг нарийвчлан тогтоох, бүтэц найрлагыг тодорхойлох зорилгоор лабораторийн шинжилгээгээр устаж үгүй болдог зүйлсийг буцаж ирэхгүй нөхцөлтэйгээр хил гаргадаг.

Иймд соёлын дурсгалт зүйлийг гадаадад гаргахдаа хууль сахиулах тэр дундаа хил хамгаалах болон цагдаа, тагнуулын байгууллагаар шалгуулдаг тогтолцоог бий болгох шаардлагатай байна. Гадаад оронд үзэсгэлэн болон судалгаа шинжилгээнд явуулах зорилгоор хилээр гаргаж буй соёлын дурсгалуудыг явуулахдаа хэрхэн баримтжуулах, хаана, хэн хариуцаж хийх, яаж хүлээлцэх, ямар баримт бичиг үйлдэх, даатгалын асуудлыг хэрхэн шийдэх, тухайн дурсгал алга болсон, гэмтсэн, хуулбар хийгдсэн, хугацаандаа ирээгүй, үрэгдүүлсэн тохиолдолд хэрхэн хариуцлага тооцох, хохирлыг хэрхэн барагдуулах асуудлыг журам гаргаж зохицуулах зайлшгүй шаардлага ч бий болсон байгаад дүгнэлт хийх цаг болжээ.

**4. Соёлын дурсгалт зүйл, музейн үзмэр, эртний амьтны, ургамлын өвөрмөц ховор үнэт олдвор, археологи, палеонтологийн олдвор, эд өлгийн зүйлсд тавих хяналтад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх.Монгол** Улсын Засгийн газрын 1998 оны 172 дугаар тогтоолоор манай улсад анх удаа соёлын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, стандартын шаардлагыг хангуулах, түүх, соёлын дурсгалт зүйлийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл мэдээллийг боловсронгуй болгоход чиглэгдсэн төрийн хяналт шалгалт хийгдэж эхэлсэн байдаг. 2004 онд Соёлын өвийг хамгаалах тухай хуулинд орсон нэмэлт өөрчлөлтөөр түүх, соёлын үл хөдлөх дурсгалд байгаль орчны хяналтын улсын байцаагч хяналт тавих бололцоо нээгдсэнээр монгол оронд соёлын өвийн хяналтын тогтолцоо бүрдүүлэхэд чухал алхам болсон гэж үздэг.

2005 оноос хойш жил бүр Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд байнгын удирдамжаар шалгалт хийх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж, байгаль орчны хяналтын улсын байцаагчдыг гарын авлагаар хангах, сургалтанд хамруулах зэрэг арга хэмжээ авсаар ирсэн боловч дорвитой үр дүнд хүрэхгүй байна. Энэ нь сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагчдын ажлын ачаалал их, хяналтын босоо удирдлагын тогтолцоонд хамрагдаагүй, соёлын өвийн талаархи мэдлэг, сум орон нутгийн удирдлагын дэмжлэг дутмаг, сумын соёлын төвтэй ажлын уялдаа тааруу байгаатай холбоотой байна.

Монгол Улсын тусгаар тогтнолын баталгаа, түүхийн баримт болох соёлын өвөөр харийнхантай нийлж бизнес хийгчдийн бүхэл бүтэн сүлжээ бий болж, хууль бусаар малтлага хийх, хилээр нэвтрүүлэх зөрчил газар авсан өнөөгийн нөхцөлд соёлын өвийн зөрчлийн талаархи баримтуудыг хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр тогтмол сурталчилж сэрэмжлүүлэх, иргэдийг хууль зөрчигчдийн тухай мэдээллийг холбогдох байгууллагад өгч хэвшүүлж, мөн соёлын өвийн зөрчлийн талаархи мэдээлэл өгсөн этгээдэд урамшуулал олгох эдийн засгийн хөшүүргийн арга хэмжээг ч авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Энэ бүхнээс дүгнэхэд энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, шалгах ажиллагаанд хил, гаалийн болон хууль сахиулах байгууллагын түүнчлэн мэргэжлийн байгууллагын хамтын ажиллагаа чухал байгаа нь харагдаж байна.

Дээрхи нөхцөл байдалд зөвхөн улсын дотоод хамтын ажиллагаанаас гадна гадаад түүний дотор хөрш орнуудын болон олон улсын хамтын ажиллагаа нэлээд чухал ач холбогдолтой.

Түүх, соёлын дурсгалт зүйлс алдагдсаар байна, хууль бусаар хил нэвтрүүлэх, экспортлох гэмт бүлэглэлийн сүлжээ бий болж их хэмжээний хор хохирол учирч байна гэдгийг тоочоод, хараад сууж цаг одоо нэгэнт биш болсныг цаг хугацаа ч тодорхойлж байна.

Иймд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны арга тактикийг өөрчлөх, түүнийг мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах тусгай чиг үүрэгтэй нэгж албыг ч байгуулж болох шаардлага байгааг өнөөгийн нөхцөл байдал мөн харуулж байна.

## Эх сурвалжийн жагсаалт

**Хууль, эрх зүйн акт:**

-Монгол Улсын Үндсэн хууль. 1992.

-Гаалийн тухай хууль. Цахим эх сурвалж, холбоос: http://www.legalinfo.mn/law/details/2097lawid-209

- Соёлын өвийг хамгаалах тухай хууль. Цахим эх сурвалж, холбоос: http://www.legalinfo.mn/law/details/455

- Соёлын тухай хууль. Цахим эх сурвалж, холбоос: http://www.legalinfo.mn/law/details/454

- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль. Цахим эх сурвалж, холбоос: http://www.legalinfo.mn/law/details/479

-Эрдэнэсийн сангийн тухай хууль. Цахим эх сурвалж, холбоос: http://www.legalinfo.mn/law/details/80

-Эрүүгийн хууль. Цахим эх сурвалж, холбоос: http://www.legalinfo.mn/law/details/50

-Монгол Улсын Их хурлын 2010 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоол. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай. Цахим эх сурвалж, холбоос: http://www.nsc.gov.mn/?q=node/119

-Монгол Улсын Их хурлын 2012 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 52 дугаар тогтоол. Төрөөс соёлын талаар баримтлах бодлого батлах тухай.

**Ном зохиол, бусад эх сурвалж:**

- *Г.Жаргалсайхан.* Соёлын эд зүйлсийн хууль бус худалдаатай тэмцэх бодлогын зөвлөмж. - УБ.: Сэлэнгэпресс хэвлэлийн газар. 2011.-5 дах тал.

- *Д.Тамир.* Монгол Улсын түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай асуудалд. Гэмт явдалтай тэмцэх асуудал. 2011. №4.

- *Ч.Доржсүрэн.Түүх* соёлын дурсгалт зүйлтэй холбоотой гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн асуудал. Магистрын ажил. - УБ. 2008. 68 хуудас.

**Цахим эх сурвалж:**

-https://www.arslan.mn/social/news/611235.shtml